

МИЛОВАН ЖИЛАСЫН КОММУНИСТ ТОТАЛИТАРИЗМЫГ ШИНЖЛЭН ШҮҮМЖИЛСЭН НЬ

Ж.Жаргал

МУБИС-ийн багш, докторант

I

Тоталитаризм бол хүн төрлөхтөний түүхэн дэх нэн хахир хатуу дэглэм байсан билээ. Эл дэглэм XX зууны 30-80 –аад онд дэлхийн арав гаруй оронд тухайн үеийн түүхэн ээдрээтэй нөхцөл байдал, тодорхой шалтгаан, хүчин зүйлийн улмаас тогтон ноёрхож байв. Түүнийг голлож өрнийн орнуудын эрдэмтэд шинжлэн судлаж олон бүтээл туурвижээ. Гэхдээ тухайн үед социалист байсан Югослав, Болгар, Чехословак, Польшийн зарим эрдэмтэд ч тоталитар дэглэм, тэр дотор өөрсдийн аж төрж байсан орны дэглэмийг дотроос нь шүүмжлэн авч үзэж сонирхолтой зохиолуудыг бичсэн байна.

Тэдгээр зохиол тухайн үед хэвлэгдэх, нийтийн хүртээл болоход хориотой байсан бөгөөд харин ихэнх социалист оронд ардчилсан хувьсгал гарсан 1990-ээд оны эхэн үеэс хойш чөлөөтэй нийтлэгдэж уншигч олны хүртээл болжээ. Тийм бүтээлийн тоонд хуучны Холбооны Бүгд Найрамдах Социалист Югослав Улсын нам, төрийн том зүтгэлтэн байсан, улс төрийн нийтлэлч, зохиолч, улс төр судлагч Милован Жиласын (1911-1995) бичсэн “Шинэ анги: коммунист системд хийсэн шинжилгээ” (New Class: An analysis of the Communist System. 1957), “Сталинтай ярилцсан нь” (Conversations with Stalin. 1961), “Төгс бус нийгэм”(The Unperfect Society.1966) зэрэг зохиолууд зүй ёсоор орно. ЗХУ, ХБНСЮУ, ер социалист орнуудад шинэ социалист нийгэм байгуулах зорилтыг хэрэгжүүлэх явцад үр дүн нь эсрэгээр эргэж, коммунист хэлбэрийн тоталитар дэглэм тогтож ноёрхсныг шинжлэн үзэж дэлгэн харуулсан байна.

М.Жиласын тэдгээр бүтээл хэд хэдэн гадаад хэлээр нийтлэгдэж тоталитаризмын асуудлаар хийгдсэн эрдэм шинжилгээний ажлын эргэлтэд аль хэдийнээ орж судлагджээ. Харин манай оронд тоталитаризмын талаархи өрнийн орны эрдэмтэдийн бүтээл, түүний дотор М.Жиласын зохиолуудыг өдгөө хүртэл судлаагүй байна.

М.Жиласын дээр дурдсан гурван зохиолыг орос хэлэнд орчуулж 1992 онд Москва хотноо “Лицо тоталитаризма”(“Тоталитаризмын нүүр царай”) гэсэн нэрээр нэг ном болгож нийтлүүлжээ. Жилас түүнд талархаж өмнөх үг бичсэн байна. Бид XX зууны өрнийн улс төрийн сэтгэлгээн дэх тоталитаризмын асуудлаар хийж буй бага сага судалгааныхаа хүрээнд М.Жиласын тэдгээр зохиолыг уншиж судлах, агуулга, үзэл санааг нь гаргаж тавихыг оролдсны эхний үр дүн болгож эл өгүүллийг бичиж бэлтгэсэн болно.

II. Намтар, бүтээл туурвилын тойм

Милован Жилас бол Югославын улс төрийн нэрт зүтгэлтэн, улс төр судлагч эрдэмтэн, нийтлэлч хүн юм. Тэрбээр Югославын коммунист намын хамгийн анхан шатнаас дээд шат хүртлэх бүхий л дамжлагыг туулан дээш гарч чадсан чадварлаг улс төрчдийн нэг байв. Жилас их сургуулийн өндөр

боловсролтой, онолын мэдлэг сайтай, орос, франц хэлтэй, тухайн үеийн Югославын төрийн удирдлага дах шилдэг сэхээтэн байжээ.

Тэрбээр 1911 онд Черногорын Колашина хотын дэргэдэх Подбишце тосгонд төржээ. Түүний эцэг нь балканы дайн болон дэлхийн нэгдүгээр дайнд оролцож явсан Черногорын армийн хошууч цолтой офицер байв. Жиласын хоёр ах, мөн эгч нь дэлхийн II дайнд амь үрэгджээ. Жилас 1929 онд Белградын их сургуулийн философийн факультетийн утга зохиол, хууль зүйн салбарт элсэн орж 1933 онд төгсчээ. 1932 онд Югославын коммунист намд элссэн байна. 1937 онд нам доторхи бүлэглэлүүдийн хооронд зөрчил үүсэхэд Жилас Броз Титог дэмжиж байв. Тэрбээр 1938 онд Югославын коммунист намын Төв Хорооны гишүүн, 1940 оноос Улс Төрийн Товчооны гишүүн болжээ. Испаны иргэний дайны үед олон улсын бригадын бүрэлдэхүүнд орж тулалдсан байна. Жилас дэлхийн II дайны үед Югославт партизаны хөдөлгөөнийг зохион байгуулан удирдах үйл хэрэгт гол үүрэг гүйцэтгэжээ. Тэрбээр Броз Титогийн хамгийн итгэлтэй, ойр дотны хүн байв. Жилас дайны дараа Черногорын асуудал хариуцсан сайдаар ажиллаж 1953 онд Югославын дөрвөн дэд ерөнхийлөгчийн нэг болсон бөгөөд эрх мэдлээрээ Титогийн дараа ордог байв. Энэхүү дөрөв нь Б.Тито, Э.Кардель, А.Ранкович, М.Жилас нар юм.

Жилас төрийн өндөрлөгт гарсны дараа улс орных нь замнаж буй зам, намынх нь үйл ажиллагаа түүний бодож төсөөлж байснаас огт өөр, гаж буруу байгааг мэдэрсэн байна. Ийм байдалтай эвлэрээгүй, үзэл бодлоо ил тод зоригтой гаргаж тавьсан учир нам, төрдөө гадуурхагдаж, шоронд хоригдон, гэрийн хорионд байж, ямагт мөрдлөг хяналтанд байжээ. Гэвч түүний итгэл алдраагүй бөгөөд тоталитаризм болж хувирсан коммунист дэглэм системээрээ нурж унахыг харж чадсан байна. Тэрбээр 1995 онд 84 насандаа таалал төгсчээ.

Нийгэм судлагч бусад эрдэмтэдээс Жиласын ялгарах ялгаатай нь тэрбээр өөрөө тоталитар төрийн дээд удирдалгын бүрэлдэхүүнд байж, Сталин, Молотов, Тито зэрэг коммунист дэглэмийн удирдагчидтай уулзаж, тэдэнтэй хамтран ажиллаж байсанд оршино. Энэ нь түүнд тоталитар дэглэмийг дотроос нь илүү сайн танихад тусалжээ. Тэрбээр улс орон, өөрөө гар бие оролцож байгуулсан нам нь түүний бодож байснаас огт өөр замаар явж байгааг олж харжээ. Жилас нам төрийн удирдах албан тушаалтнууд тусгай хангамж эдэлж, баян тансаг амьдарч, намын дүрэм, хууль ёсонд захирагдахаа больсон, улс орны амьдралын бүх салбарын үйл ажиллагаанд хөндлөнгөөс зүй бусаар оролцох болсон, жирийн ард олон эрх чөлөөгүй, өмч хөрөнгөгүй ядуу амьдрах болсонд дургүйцэх болсон байна.

Жилас 1953 оноос эхэлж Югославын коммунист намын үйл ажиллагаа, удирдагчидыг идэвхтэй шүүмжлэх болжээ. 1953-1954 онд "Тэмцэл" сонинд хэд хэдэн өгүүлэл нийтлүүлсэн нь ихээхэн шуугиан тарьсан байна. Тэрбээр эдгээр өгүүлэлдээ Сталины удирдлагын арга барил Югославт ч бий болж байгаа, тухайлбал коммунист нам прокурорын байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож байгааг эрс шүүмжлээд шинэ социалист нам байгуулах тухай үзэл бодлоо илэрхийлжээ. Энэ бүгдийнх нь төлөө Жиласыг 1954 онд нам,

төрийн бүх албан тушаалаас нь халж, намаас хөөсөн байна. Тэрбээр энэ тухай сүүлд бичихдээ “Би хэзээ ч улс эх орон, нам, төр, хамтран зүтгэгч нөхдийнхөө эсрэг хорон санаа өвөрлөж байгаагүй, гагцхүү одоогийн нийгмийн байдлын тухай өөрийн үзэл бодол, түүнийг илүү сайхан болгох тухай санлаа л хэлэхийг хүссэн юм” гэжээ⁸¹.

Жилас 1956 онд Унгар улсад гарсан бослого, тэмцлийг идэвхтэй дэмжиж, Титогийн дэглэм, коммунизмыг шүүмжилсэнийхээ төлөө 3 жилийн хорих ял авчээ. Шоронд байхдаа “Шинэ анги: коммунист системд хийсэн анализ” (New Class: An Analysis of the Communist System) бүтээлийнхээ гар нооргыг бичиж дуусгажээ. 1957 онд АНУ –д “Шинэ анги” бүтээлийн ноорог хувь гараас гар дамжсаар хэвлэгдэн гарсан байна. Учир нь түүний бүтээлүүдийг Югославт хэвлэн борлуулахыг хориглож байв. Жилас эл бүтээлдээ коммунист дэглэмийн мөн чанар, шинж, түүний бий болгосон тоталитар дэглэм, шинэ анги буюу номенклатурын тухай авч үзсэн байна.

Жилас Сталинтай хоёр удаа хувиараа, хоёр удаа Югославын нам, төрийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж уулзжээ. Жилас өөрийн дурсамж номоо бичиж байх үедээ Сталинтай уулзсан тэдгээр уулзалтын тухай, тэр үеийн хоёр орны харилцааны тухай ном бичих санаа төржээ. Тэр дагуу бичсэн түүний “Сталинтай ярилцсан нь” ном нь 1961 онд хэвлэгдсэн бөгөөд зохиогч түүндээ улсын нууцыг номондоо дэлгэн задруулсан гэсэн хэргээр дахин хоригджээ. Эл ном нь 1962 онд Лондонд “Conversations with Stalin” нэртэйгээр дахин хэвлэгдсэн байна.

Жилас 1966 онд шоронгоос суллагдан гарчээ. Тэрбээр хэсэг хугацаанд гадаадад амьдарч лекц уншдаг байв. 1966 онд “Төгс бус нийгэм” (The Unperfect Society) номоо хэвлүүлжээ. Жиласын эдгээр гурван ном хамгийн алдартай нь юм. Үүнээс гадна “Шударга ёсгүй газар нутаг” (Land without Justice, 1958), “Хувьсгалын дурдатгал” (Memoir of a Revolutionary, 1973) “Дайны үе” (Wartime, 1977), “Шорон ба үзэл санааны тухай” (Of Prisons and Ideas, 1984) “Тито: Нууц түүх” (Tito: story from inside, 1980), “Сэргэн мандалт ба уналт” (Rise and Fall, 1986) зэрэг 15 ном бичиж эдгээр нь бүгд гадаадын хэд хэдэн хэл дээр орчуулагдан гарчээ.

1970-1986 онд түүнийг Югославаас гарахыг хориглосон байна. Жилас 1982 онд Польшийн “Солидарность”-ыг хамгаалан үг хэлж байсан бөгөөд 1990-ээд онд С.Милошевичийн бодлогыг эсэргүүцэж байв.

III. Сталин, сталинизмын тухай

Тоталитар дэглэмийн нэн чухал онцлог шинжүүдийн нэг бол түүний үүсэл, оршин тогтнол, ноёрхолд ихээхэн үүрэг гүйцэтгэдэг дарангуй толгойлогч, жолоодогч байдаг нь түүхээс нэгэнт тодорхой болсон зүйл билээ. Германд тогтож ноёрхсон фашист тоталитар дэглэм нь Гитлерийн үзэл суртал, улс төр, цэргийн үйл ажиллагаатай, ЗХУ-д тогтон ноёрхсон коммунист хэлбэртэй тоталитаризм нь Сталинтай салшгүй холбоотой. Тиймээс аль нэг оронд тогтсон

⁸¹ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 243-244

тоталитар дэглэмийг судлахдаа түүний дарангуйлагч жолоодогчийн тухай асуудлыг орхигдуулах аргагүй юм. Чухам энэ үүднээс Жиласын "Сталинтай ярилцсан нь" зохиол ЗХУ-д тогтсон коммунист тоталитаризмыг түүнийг толгойлогч Сталинаар төлөөлүүлж танин мэдэх, төсөөлөн ойлгоход багагүй тус болно.

Жилас ЗХУ-аас зэр зэвсэг, эд материалын тусламж авах асуудлыг хэлэлцэх Югославын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж 1944 онд Сталинтай анх удаа уулзсан байна. Төлөөлөгчдийн дотроос Жилас ганцаараа орос хэл сайн мэддэг, оросын соёл, уран зохиолыг сонирхдог, энэ талын болон ер нь нийгэм-улс төрийн өндөр мэдлэг, боловсролтой, ажигч гярхай, бодрол сэтгэлгээ сайтай, үзсэн харсан зүйлээ эрэгцүүлэн бодож улс төрийн дүгнэлт хийх чадвартай байв. Тэрбээр үүний дараа 1945-1948 онд ЗХУ-д гурван удаа ирж Сталин болон түүний хүрээнийхэнтэй удаа дараа уулзан ярилцаж, бусад яам, газаруудаар орж, мөн зарим хотоор явжээ. Энэ нь Жилас ЗХУ-ын байдал, эл оронд тогтсон улс төрийн дэглэм, түүний удирдагч, нам, төр, цэрэг армийн бусад томоохон зүтгэлтнүүдийн тухай ойлголттой болох, түүнийгээ хожим бодож, эрэгцүүлэн дүгнэсэн ном бичих үндэслэл болжээ. Үүний дагуу бичигдсэн Жиласын тус зохиол зөвхөн Сталин болон түүний хамтран зүтгэгчдийн тухай ердийн нэг дурдатгал биш, харин тухайн үеийн ЗХУ-ын байдал, Сталинист дэглэмийн тухай нарийн бодрол эрэгцүүлэл, онол-танин мэдэхүйн ба нийгэм-улс төрийн чанартай сонирхолтой үнэлэлт дүгнэлтүүдийг агуулсан улс төр судлалын бүтээл болж гадаадын эрдэмтэн судлагчдад үнэлэгдэн танил болсон байна.

Жилас зохиолдоо тухайн үеийн ЗХУКН, Зөвлөлт төрийн гадаад бодлогын асуудал, түүний дотор Югослав улсын талаар баримтлаж байсан бодлого нь эл орныг эхнээсээ өөрийн нөлөө, хяналтанд байлгаж дуулгавартай дагуул улс болгоход чиглэсэн, Интернационал, Нийт славяны хороо зэрэг олон улсын байгууллага бол ЗХУ-ын гадаад бодлогын хэрэгсэл бүхий тоглоом байсаныг баримтаар өгүүлээд тэр үед Коминтерны нарийн бичгийн даргаар Москвад сууж байсан Г.Дмитров, Мануильский нарын байр суурь, үзэл бодол Москвагаас хараат шинжтэй байсныг зураглан гаргажээ.

Зохиолд тэр үед ид явагдаж байсан дэлхийн II дайны явц, Зөвлөлтийн Улаан арми, түүний офицер, цэрэг байлдагчдын үйл ажиллагаа, цэргийн мэдлэг мэргэжил, боловсрол, нийгэм-улс төрийн дүр төрхийн эерэг сөрөг тал, шинжийн тухай сонирхолтой мэдээ баримт, үнэлэлт дүгнэлтийг өгүүлсэн байна. Жилас, тухайлбал Зөвлөлтийн армийн байдал, бүрэлдэхүүнийг бүхэлд нь дүгнэн цэгнэхдээ "Цэргүүд болон офицерууд улс төрийн хувьд хэт нэг талыг барьсан боловч идэвх санаачилагатай, соёл, үзэл бодлын тал дээр өргөн сэтгэдэг. Хатуу чанд зарчимтай, гол зорилго, хүлээсэн даалгавартаа бүх зүйлээ зориулдаг. Тэднээс марксист сургаалын гүн мэдлэг шаарддаггүй бөгөөд хамгийн гол нь байлдааны талбараас ухарч огт болохгүйг шаарддаг. Сталин армид их цэвэрлэгээ хийсний үр дүнд залуу, авьяаслаг офицерууд гарч иржээ. Сталины энэ алхам нь нэгдүгээрт, армийг бүрэн хянах бололцоо өгч, хоёрдугаарт түүний

байлдах чадварыг дээшлүүлж, доороос ур чадвартай хүмүүс олноор гарч ирэхэд хүргэсэн” гэж Жилас бичсэн байна⁸².

Жилас зохиолдоо гол болгож өгүүлсэн зүйл бол ЗХУ-д тогтож ноёрхсон сталинист хэлбэрийн коммунист тоталитаризмын тулгуур багана болсон И.В.Сталины улс төр, цэргийн үйл ажиллагаа, үзэл санаа, онолын төсөөлөл, бие хүний зан чанар, үйл байдал, түүнчлэн удирдагчийн ойрын зарим хамтран зүтгэгчдийн үйл ажиллагаа, дүр төрхийн тухай юм. Жилас Сталинтай анх 1944 онд уулзахдаа түүний дүр төрх, зан байдлын талаар өөрт нь бүрэлдсэн төсөөлөл, санаа бодлыг дараах байдлаар дүрслэн өгүүлжээ. “Гэрийн эзэн маршалын дүрэмт хувцасаа өмссөн, түүндээ Зөвлөлт Холбоот Улсын Социалист хөдөлмөрийн баатарын алтан таван хошуугаас өөр ямар ч одон, тэмдэг зүүгээгүй ажээ . . . Энэ хүн бол гэрэл зураг, баримтат кинон дээр гардаг нөгөө агуу их Сталин биш байлаа, харин мод шиг хөшүүн, удаан алхаатай хүн байв. Тэрбээр нэг ч секунд тайван суусангүй. Гаансаараа оролдож, хөх өнгийн харандаагаар хэлэлцэж буй асуудлын гол сэдвийг тэмдэглэн, түүнийгээ баллуурдаж байлаа. Намайг өөр нэгэн зүйл гайхаш төрүүлээ. Тэр нь Сталины жижигхэн бие, этгээд гадаад байдал юм. Цээжин бие нь богинохон, бас давчуу, хөл гар нь хэтэрхий урт, зүүн гар болон зүүн мөр нь хөдөлгөөн муутай байв. Нүүр нь цагаан, хацар нь улаан туяа суусан байлаа. Сүүлд сонсоход ийм нүүртэй хүмүүсийг “Кремлийнхэн” гэж нэрлэдэг болохыг мэдсэн юм” гэж Жилас дүрслэн бичжээ⁸³.

Жилас, Сталин хувийн зохион байгуулалт сайтай, өөрийгөө сайн хянаж чаддаг, гайхалтай сайн ой ухаантай, уран зохиолын баатарууд, бодит хүмүүсийг нарийн тодорхой, алдаагүй зааж, чухал үйл явдалуудыг дурсаж, улс орнууд, төрийн зүтгэлтнүүдийн хүчтэй ба сул талыг тайлбарлан хэлж байсан хэмээн үнэлсэн байна.

Жилас Сталинтай ярилцаж байх үедээ түүнийг орос хүн биш гэдгийг мэдэрсэн гэжээ. Гэхдээ Сталины орос хэлний үгсийн сан маш баялаг байсныг магтжээ. Сталин хошин шогийн мэдрэмж сайтай, доог тохуу их хийдэг хүн байжээ. Тоглоом шоглоом хийхдээ бүдүүлэгдүү, өөртөө их итгэлтэй боловч шоглоом нь голыг олоогүй, гүн утга санаа агуулдаггүй байжээ.

Жилас Сталинтай 1948 онд сүүлчийн удаа уулзахад тэрбээр хөгширсөн, сэтгэн бодох логик нь өөрчлөгдсөн, гэхдээ зан авир нь эрс, хурц, болгоомжтой, хардамтгай хэвээр байсныг тэмдэглэн бичжээ.

Жилас Сталины тухай өөрийн санал сэтгэгдлээ нэгтгэж дараах дүгнэлтийг хийжээ. “Сталин бол гарамгай улс төрч юм. Тухайн цаг үеийн хамгийн гарамгай нь ч байж болно. Хаант Оросын хоцрогдсон ядуу орныг аж үйлдвэржсэн хүчирхэг улс болгосон хүн бол гарцаагүй Сталин мөн. Тэрбээр өөрийнхөө номлолыг бодит амьдрал дээр хэрэгжүүлж чадсан юм. Аливаа улс төрчдийн нэгэн адил засгийн эрхийн төлөө тэмцсэн нь жам ёсных боловч Сталины энэхүү

⁸² Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 20

⁸³ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992.22-23

тэмцэл нь байх ёстой хил хязгаарыг хэтэрхий хол давчихсан ажээ. Бусад дарангуйлагчидын нэгэн адил түүний алданууд нам, төр, нийгмийн дотор амархан нэвтрэн орж, аймшигтай гэмт хэрэг болон хувирсан юм. Өнөөдрийг хүртэл Сталин энэ бүх зүйлсийг шинэ нийгэм байгуулах үзэл санаагаа хэрэгжүүлэхийн төлөө хийсэн үү, аль эсвэл засгийн эрхийн төлөөх шуналаасаа болж хийсэн үү гэдэг нь тодорхойгүй байна. Би түүний үйлдэлд эдгээр элементүүд бүгд байсан гэж бодож байна. Сталин түүхэнд яахын аргагүй онцгой байр суурь эзлэнэ, гэхдээ сөрөг утгаар. Түүний үйл ажиллагаанаас эерэг зүйл олоход хэцүү юм. Сталин бол тэнүүчлэн хэсэж байгаа, цаашдаа ч дэлхийгээр хэрэн хэсэх хий үзэгдэл юм. Түүний үлдээсэн өвөөс бүгд цааргалаж, холдож байгаа ч түүнээс нь хүч чадлаа олж авч байгаа хүн олон байна. Өнөөдрийн зөвлөлтийн удирдагчид түүнийг биширдэггүй ч түүний нарны туяанд биеэ ээцгээж байна” гэжээ⁸⁴.

Жилас зөвхөн Сталиныг онцлон авч үзээгүй, бас тухайн үеийн зөвлөлтийн томоохон удирдагчидын зан чанарт ч үнэлэлт өгчээ. Тухайлбал тэрбээр Молотовыг үг дуу цөөнтэй, Сталинтай цуг байх үедээ маш сайхан зантай, хувиараа ярилцах үед маш хаалттай хэмээжээ. Сталин өөрийн хүрээнийний дотроос ганцхан Молотовыг чи (ты) гэж дууддаг, бусдыг нь та (вы) хэмээн дууддаг байжээ. Черчилль Молотовыг хамгийн орчин үеийн робот хэмээн хэлсэн байдгийг Жилас онцлон тэмдэглэсэн байна.

Жилас Бериятай анх уулзаад “дөрвөлжин уруул, хавчдаг шилний цаанаас харах бах мэлхийний харц нь коммунистуудыг тарчлаан зовоодог байсан Белградын хааны цагдаагийн газрын дарга нарын нэг Вуйковичтай адилхан харагдсан” хэмээн эгдүүцсэн байна⁸⁵.

Маленковыг зожиг, хурц тод зан төрхгүй, анхаарал болгоомжтой хүн гэжээ. Маленков бол удаан хугацааны туршид намын асуудал хариуцсан Сталины албан бус орлогч байв. Намын зохион байгуулалттай холбоотой бүх үйл ажиллагаа түүний гарт байсан ажээ. Жилас Маленковыг “номенклатурчуудын жагсаалтыг” бүрдүүлэн гаргасан бөгөөд түүнд нь намын хэдэн сая гишүүдийн хувийн хэрэг багтдаг байсан гэжээ.

Сталин Югославын төрийн томоохон зүтгэлтнүүдийн дотроос Жиласт илүү ойр дотно ханддаг байжээ. Сталин түүнийг Хар далайд цуг амрахыг хүртэл урьж байв. ЗХУ болон Югославын хооронд зөрчил үүсэх үед Сталин Жиласыг өөрийн талдаа татахыг их хичээсэн боловч тэр санаа нь бүтээгүй байна.

Жилас зохиолдоо дээр дурдсан олон зүйлийн талаар өгүүлснээр Сталин ба түүний удирдсан ЗХУ-ын нийгэм-улс төрийн байдал, шинж чанарын тухай зохиогчийн үзэл санаа, ойлголт, дүгнэлт нь тарамдаж бүдгэрээгүй, харин ч эл оронд тогтсон тоталитар дэглэмийн дүр төрх тодорхой хэмжээгээр бүхэл байдлаар зурагдан гарчээ.

⁸⁴ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992.72-74

⁸⁵ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992.37

IV. Коммунист тоталитаризмыг шинжилсэн нь

Жиласын хамгийн алдартай, нийгэм улс төрийн үзэл санаа нь тод туссан бүтээл нь “Шинэ анги” гэсэн зохиол юм. Түүнийгээ 1957 онд шоронд байхдаа бичиж дуусгажээ. Энэхүү бүтээлд нь тоталитаризм, түүний нэгэн илрэл болох коммунизмын тухай, мөн номенклатур давхаргын талаархи үзэл санаа нь тусгагджээ.

Жилас номныхоо эхний хэсэгт коммунист сургаалын үүсэл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлс, гол гол сэтгэгчидийн талаар авч үзжээ.

Жилас коммунист хувьсгал гарах болсон шалтгаан бол (Орос, Хятад, Югославт) аж үйлдвэржилтийг эрчимчүүлж, энэ салбарт өөрчлөлт хийх амин чухал хэрэгцээнээс үүдэлтэй гэж үзжээ. Аж үйлдвэр нь хоцрогдсон, эдийн засаг нь сул дорой эдгээр оронд нийгмийн байдлыг тогтворжуулах, ард түмний амьдралыг сайжруулах ганц арга зам бол аж үйлдвэрээ хөгжингүй орнуудын хэмжээнд хүргэх явдал байжээ.

Өмнөх хувьсгалуудад заавал дайн хийх шаардлага гардаггүй байсан бол коммунист хувьсгалд дайн бол ялалтыг нь баталгаажуулж өгдөг гол зүйл ажээ. Жилас үүний жишээ болгож Хятад, Испаныг авч үзжээ. Хятадад хэдэн арван жил үргэлжилсэн дайнд коммунистууд ялалт байгуулж хувьсгал амжилттай болсон бол Испанид коммунистууд ялагдаж хувьсгал бүтэлгүйтсэн түүхтэй. Коммунист хувьсгалыг хийхэд нийт ард түмний дэмжлэг шаардлагагүй бөгөөд гагцхүү хувьсгалын амжилтанд бүрэн итгэсэн, нэгдмэл цөөнх хангалттай гэж Джилас үзсэн байна. Коммунистуудын ялалт нь намын зохион байгуулалт, хатуу сахилга бат, үнэнч, тууштай зан чанар, ялалтанд бүрэн итгэх итгэл үнэмшлээс ихээхэн хамаардаг ажээ.

Жилас коммунист хувьсгалд ард түмэн оролцдог ч тэд эцэстээ юу ч олж авдаггүй, хувьсгалын үр шимийг хэсэг хувьсгалчид болон тэднийг тойрон хүрээлсэн бюрократууд хүртдэг гэжээ. Хувьсгал хийхэд гар бие оролцсон хувьсгалчдыг ихэвчлэн устгадаг, харин аж үйлдвэрийн салбарт хэрэгтэй мэргэжлийн хүмүүсийг үлдээдэг байна.

Коммунист хувьсгалын үр дүнд өмчийн шинэ хэлбэр болох нийтийн өмч бий болж хувийн өмч устан алга болдог бөгөөд энэ нь хоёр шалтгаантай. Нэгд, ард түмэнд тэгш байдал, шударга ёсыг тогтоож буйг харуулна, хоёрт, аж үйлдвэржилтийг амжилттай явуулахад чухал нөлөөтэй. Учир нь ЗХУ, Хятад зэрэг дөнгөж хувьсгал ялсан хөгжил сул дорой оронд эдийн засгийг хөл дээр нь босгож тогтооход улс орны бүх баялагийг нэгтгэн төвлөрүүлэх нь зайлшгүй шаардлагатай болдог байна. Гэвч энэ бүхэн хангалтгүй. Аж үйлдвэржилт явагдаж байгаа үед бүх давхаргын өмчийг, түүний дотор хувьсгалд тусалсан хэсгийнхэний өмчийг ч булааж авна. Төр өмчийн албан ёсны эзэн болж захиран зарцуулж хуваарилдаг. Ингэснээр төр эдийн засгийн салбарт хүссэн үйл ажиллагаагаа явуулах боломжтой болдог байна. Ийм нөхцөлд хувийн өмч устаж алга болдог, эсвэл үүрэг нөлөө нь ямар ч ач холбогдолгүй болтлоо буурдаг ажээ. Жилас, коммунистууд болон энгийн олон түмэн энэ бүхнийг өмч устаж, ангигүй нийгмийн тухай үзэл санаа хэрэгжиж байна хэмээн ойлгодог гэжээ.

Жилас демагоги, булзамхай зан, эмх журамгүй байдал нь коммунист удирдагчидын шинж бөгөөд тэр нь төгс нийгмийг амлаж, "бүх төрлийн мөлжлөгийг халах" тухай ярих үед нь тод илэрдэг гэсэн байна. Энэ нь коммунистууд ард түмнийг хуурсан гэсэн үг биш бөгөөд тэд зүгээр л амласнаа биелүүлэх чадваргүй юм. Хэргийн учир нь тэд чин сэтгэлээсээ итгэж байсан зүйлсээ биелүүлж чадахгүй байв. Тийм атал коммунистууд амалсан зүйлсээсээ огт өөр зүйлийг хийж байгаагаа хүлээн зөвшөөрдөггүй, тиймээс коммунист хувьсгал нь дарангуйлал руу хөтлөдөг, ард түмнийг тэдний огт хүсэхгүй байгаа замаар замнуулдаг гэжээ.

Жилас коммунист хувьсгал нь ангийг устгах зорилго тавьдаг ч өөр нэг дарлагч шинэ ангийн ноёрхолыг тогтоодог гэж үзжээ. Энэхүү шинэ ангийн үр хөврөл нь намын цөмийг бүрдүүлж байсан мэргэжлийн хувьсгалчдын дунд үүсчээ. Коммунист нам бол түүний цөм үндэс нь юм. Шинэ анги бэхжих тусам намын үүрэг роль улам бүр багасдаг, идэвх санаачлагатай байсан нам идэвхгүй, бүтэц зохион байгуулалтгүй болж шинэ ангийн олигархуудын жин нөлөөг нэмэх хүч болж хувирдаг байна⁸⁶. Нам ангийг төрүүлдэг. Анги өсөн хөгжиж, харин нам сулран доройтдог. Энэ бол аль ч коммунист намын хувь заяа юм гэж Жилас үзжээ.

Аж үйлдвэржилт, нийгэмчлэл амжилттай явагдаж, капиталист өмч устсанаар ЗХУ ангигүй нийгэмтэй болох ёстой байв. 1936 онд батлагдсан ЗХУ-ын Үндсэн хуулинд ЗХУ-ыг дарлагч ангигүй болсон хэмээн тунхагласан боловч үнэн хэрэгтээ хүн төрөлхтөний түүхэнд байгаагүй шинэ дарлагч анги аль хэдийнээ бий болсон ажээ. Жилас эл шинэ анги нь бюрократ, түүний дотор улс төрийн бюрократуудын анги бөгөөд өмнөх нийгэмд байсан ангиудын бүх шинжийг агуулахаас гадна өөрийн онцлог дүр төрхтэй болохыг гарган тавьжээ. Энэхүү шинэ ангийн гоц ялгарах шинж бол онцгой төрлийн нийтийн өмч ажээ. Хувийн өмч нийтийн өмч болж хувирах үйл явц удаан алгуур явагдсан бөгөөд шинэ анги нь өөрийн хүч чадал, эрх дарх, үзэл суртал, амьдралын хэв маягаа нийтийн өмчөөс олж авсан байна. Хэрвээ хүмүүс хувийн өмчтэй хэвээр үлдвэл шинэ анги ноёрхолоо тогтоож чадахгүй гэж Жилас бичжээ.

Шинэ ангийн оюун санааны амьдрал, уг үндэсийг тавьсан хүн бол Ленин юм. Тэрбээр большевик намыг байгуулж, түүний шинэ нийгэм дэх үүрэг ролийг нь зааж өгсөн, Харин Сталин бол шинэ ангийг хөл дээр нь босгон бэхжүүлж, ноёрхлыг нь тогтоосон гэж Жилас өгүүлжээ.

Жилас Шинэ анги оршин тогтнох, эдийн засгийн хувьд түшиж тулах хүч бол аж үйлдвэр ажээ. Шинэ анги аж үйлдвэржилт хоёр хоорондоо салшгүй холбоотой. Тиймээс Сталин аж үйлдвэржилтийн хөгжлийг эрчимжүүлэхгүй бол шинэ анги оршин тогтнож чадахгүй гэдгийг сайтар ойлгожээ. Аж үйлдвэржилт шинэ ангид эд баялаг, эрх мэдлийг өгч, хариуд нь шинэ анги аж үйлдвэржилтийг дээд хэмжээнд нь тултал хөгжүүлэхийг зорьсон байна. Аж үйлдвэрийн хөгжил намын гишүүдийн өсөлтөд хүчтэй нөлөөлжээ. 1927 онд аж үйлдвэржилтийн

⁸⁶ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992.93

өмнө ЗХУ-ын коммунист нам 887233 гишүүнтэй байсан бол 1934 онд 1847488 гишүүнтэй болж өсчээ⁸⁷.

Жилас Троцкий ба Сталин нарын зөрчил бол нэг талаас Сталин өөрийн шинэ ангийг бэхжүүлэх гэсэн, нөгөө талаас Троцкий түүнийг эсэргүүцсэн зөрчил байсан гэж үзсэн байна.

Жилас шинэ анги, ер нь Орос дахь коммунизмын хөгжил нь гурван үеийг туулсан, түүний эхний үе нь Лениний хувьсгалын үе, дараагийнх нь Сталины үе, сүүлийнх нь хамтын удирдлага (Хрущев, Маленков, Булганин, Шепилов) буюу олигархи бүлэглэлийн үе юм, харин Югославын коммунизмын хөгжил нь Б.Тито гэсэн ганц хүнтэй холбоотой гэжээ.

Шинэ анги улсын өмчийг захиран зарцуулах эрхтэй болсон явдал тэдний сэтгэл зүй, амьдралын хэв маягийг өөрчилсөн байна. Нийгэмд хэн, ямар байр суурь эзэлж байгаасаа хамааран хамгийн сайхан байр, зуслан, машин эзэмшиж, тусгай газар амьдарч, олон түмэнд хаалттай амралтанд амрах болжээ. Энэ бүхэн нь шинэ ангийг мөлжигч, дарангуйлагч анги болгон хувиргажээ. Жилас орчин үеийн коммунизм бол нэн түрүүнд өмч эзэмшигч мөлжигч шинэ ангийг тээгч гэж үзжээ.

Шинэ ангийн эдийн засаг, нийгмийн байдал, нэг намын зохион байгуулалт нь түүнийг урьд өмнө нь түүхэнд байгаагүй хамгийн нарийн зохион байгуулалттай, үргэлж ухамсартай, сайтар бодож байж үйл ажиллагаа явуулдаг анги болгосон байна. Ийм нийгэмд жирийн иргэд албан тушаал ахиж дээш гарах бололцоо онолын хувьд нээлттэй. Гэхдээ энэ нь тухайн хүнээс гагцхүү намд (шинэ ангид) тууштай, чин үнэнч байхыг шаардна. Үүнээс гадна өрсөлдөгчтэйгээ шийдвэртэй тэмцэх зоригтой, намын дотоод зөрчилд ухаалаг, зальтай ханддаг байх хэрэгтэй. “Бусдын хүүрэн дээгүүр алхах” чадвар нь удирдах албан тушаалд тавигдахад тус болдог байна⁸⁸. Шинэ анги нь нэгэн зэрэг нээлттэй, бас хаалттай ажээ.

Жилас коммунист төрийн механизм нь эцсийн дүндээ хамгийн нарийн зохион байгуулалттай дарлал, аймшигт мөлжлөгт хүргэдэг гэжээ. Коммунист төрийн бүхий л үйл ажиллагаа зөвхөн коммунист намын заавар, удирдамжын дор явагдана. Нийгэм, эдийн засгийн амьдрал намаас бүрэн хамааралтай болно. Намын хөндлөнгийн оролцоог хуульчилаагүй ч тэр нь хэрэг дээрээ нийгмийн үйл ажиллагааны бүх салбарт нэвтэрч тархсан байдаг ажээ. Хуулинд, бусад ямар ч баримт бичигт шүүх, прокурор нь нууц цагдаагийн хяналтанд байх ёстой гэж бичээгүй ч тэр нь коммунист дэглэмтэй улсад бодит байдал дээр огт өөр байдаг. Ийнхүү коммунист нам нь тоталитар нам болж хувирчээ. Төрийн удирдах албан тушаалд зөвхөн намын гишүүд тавигддаг. Тухайлбал нууц цагдаа, дипломат алба, армийн удирдлага, аж үйлдвэрийн газруудад коммунист намын гишүүд дүүрэн байна. Жилас ийм бодит байдалд дүн шинжилгээ хийгээд

⁸⁷ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 97

⁹⁵ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 102-103

коммунист орон нь “коммунист засаг – намын засаг, коммунист арми – намын арми, төр – нам төвтэй төр” гэсэн бүтэц, зохион байгуулалттай болдог ажээ⁸⁹.

Коммунист намд үзэл суртлын нэгдэл онцгой байр суурь эзэлнэ. Нэгдмэл үзэл суртлын тусламжтайгаар намын дээд удирдлага доод шатны гишүүдийнхээ оюун санааг хянаж чаддаг. Намын үзэл суртлын нэгдэл нь аливаа удирдагч намд хувийн диктатураа тогтоох оюун санааны үндэс болж өгдөг байна. Жилас үзэл санааг тодорхой хүмүүсийн оюуны хөдөлмөрийн үр дүн, харин түүний нэгдэл нь ердөө дарангуйлалыг халхлаж нуусан “онолын баг” байдаг хэмээжээ (Милован Джилас, 1992, 109).

Коммунист төрийн гол хүч нь нам юм. Нам бол бүх зүйлсийн анхдагч, хөдөлгүүр болно. Гагцхүү коммунист нам л нийгэмд бүрэн хяналтаа тогтоож чадах бөгөөд өөр ямар ч хүч тэгж чадахгүй.

Коммунизм дах намын олигархуудын дарангуйлал нь тодорхой цаг үеийн улс төрийн нөхцөл байдлын үр дагавар биш, харин урт удаан үргэлжлэх нарийн төвөгтэй үйл явцын үр дүн байдаг ажээ. Нам нь ард түмний нэрийн өмнөөс төрийн эрхийг барьдаг. Харин намыг түүний удирдагчид залж чиглүүлнэ. Нам нь нийгмийн амьдралын бүх салбарыг хянадаг болсноор коммунист систем нь бюрократуудыг, хатуу шатлан захирах ёсыг зайлшгүй бий болгодог байна. Тэнд улмаар удирдагчидын хаалттай хүрээ бий болно. Улс төрийн бүх бодлого энэхүү хүрээгээр дамжин хэрэгждэг, тэнд худ ургын харилцаа, овогрохох явдал цэцэглэн хөгждөг ажээ. Нэгнийхээ гэрт хоол идэх, ан хийх, хоёр гурван хүний хооронд үүсэх ярианы явцад төрийн амин чухал асуудлууд шийдэгддэг байна. Намын зөвлөгөөн, засгийн газрын нэгдсэн хуралдаан, парламентын хурал нь ёслолын төдий үүрэг гүйцэтгэдэг, учир нь хэрэг дээрээ аль хэдийнээ “гэр бүлийн гал тогоонд” “бэлэн болж чанагдсан” асуудлыг нэгэн дуугаар баталдаг байна⁹⁰.

Жилас дарангуйлагч өөрийгөө хэзээ ч дарангуйлагч гэж нэрлэдэггүй, тухайлбал гадаадынхан Сталиныг дарангуйлагч гэж нэрлэхэд тэрбээр түүнийг нь зүгээр нэг тоглоом тохуу болгон өнгөрдөг байсан гэжээ. Сталин өөрийгөө намын хамтын хүсэл зоригыг илэрхийлэгч гэж үздэг байжээ. Аль ч коммунист диктатур нь намын үзэл санааны үндэсээс холдох, шинэ ангийн монополыг үгүйсгэх, олигархуудын тоталитар эзэмшилээс татгалзах аваас бүрэн сүйрэх ажээ. Сталин олигархуудгүйгээр, эсвэл тэдний эсрэг зогссон бол хэн ч биш байх байжээ.

Коммунист системд хүн бүхэн, бүр дээд удирдлагынхан, удирдагч нь хүртэл эрх чөлөөгүй байдаг. Хүн бүхэн бие биеэнээсээ хамааралтай байх бөгөөд тиймээс туйлын болгоомжтой байх хэрэгтэй болдог. Коммунист дэглэм нь “эзэн ноёндoo түүнийг хүрээлэн буй орчин, зонхилж буй санаа бодол, амьдралын хэв маяг, эрх мэдэл, ашиг сонирхолоосоо холдох боломж олгодоггүй” байна⁹¹.

⁸⁹ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 107

⁹⁰ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 112

⁹¹ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 192

Жилас нэгэнтээ Сталиныг өөрийнхөө байгуулсан нийгмийн хохирогч, хоригдол нь юм гэж хэлсэн байна.

Лениний төрийн онол ёсоор бол ангиуд устаж, төрийн хүч нөлөө буурах ёстой байсан боловч бүх зүйл эсрэгээрээ явагдсан билээ. Жилас, Сталин онолын энэхүү цоорхойг нөхөхийн тулд төрийн “хүмүүжүүлэх” үүргийн тухай үзэл баримтлалаа гаргаж ирсэн гэжээ. Сталин үзэл баримтлалдаа төрийн хүмүүжүүлэх үүргийг цагдаа гүйцэтгэдэг гэж үзээд түүний үүрэг нөлөөг ихэд чухалчилж байв.

Жилас, коммунист төр нь хэзээ ч эрх зүйт төр болж чадахгүй гэжээ. Учир нь коммунист дэглэмд шүүх, прокурор нь төрөөс бүрэн хамааралтай байдаг, бас хууль нь бодит амьдрал дээр ёсоороо хэрэгждэггүй. Коммунист удирдагчид эрх зүйт төрийг байгуулахыг оролдох юм бол тоталитар ноёрхолоо алдах болно. Үг хэлэх, үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх зэрэг иргэний эрх, эрх чөлөөг хуулиар баталгаажуулан зөвшөөрсөн байдаг ч түүнд нь нэг нөхцөл тавьдаг. Тэр нь иргэд эдгээр эрхээ социалист нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн эдлэх явдал юм.

Хууль тогтоомжууд шинэ анги болон намын ашиг сонирхол, хэрэгцээний үүднээс батлагдаж гардаг байна. Коммунистуудыг зовоодог толгойны өвчин бол тэд өөрсдөө батлаж гаргасан хуулийг мөн өөрсдөө алхам тутамдаа зөрчих хэрэгтэй болдог явдал юм. Тэд энэ зовлонгоос салахын тулд “цоорхой” хууль баталж гаргадаг ажээ⁹².

Коммунист төрд хамгийн хэрэгтэй байгууллага бол нууц цагдаа болно. Тэр нь социализмын дайснууд болох эрүүл саруул ухаанаар сэтгэдэг, аливаа зүйлийн нарийн учрыг ойлгодог хүмүүсийг баривчилж, төрөө дотоодын олон ургальч үзлээс бат найдвартай хамгаалдаг, бас шүүх, прокурорын үйл ажиллагааг хянаж зааварладаг. Нууц цагдаа нь нийгэмд аюултай гэсэн хүмүүсийг ойр дотны найз нөхөд, хамтран ажиллагсадынханы тусламжаар илрүүлдэг байна. Нууц цагдаа нь хууль бус, нууц байгууллагуудыг илэрүүлдэггүй, харин ч тийм байгууллагуудыг өөрсдөө байгуулж, түүндээ социализмд таагүй хандагсадыг татан оруулаад дараа нь баривчилдаг. Коммунист төр “итгэж үл болох” иргэдийг ухааруулан сэнхрүүлж өөртөө татах бус, харин эсрэгээр нь гэмт үйлдэл, төрийн эсрэг үйл ажиллагаанд түлхэн оруулдаг гэж Жилас бичжээ⁹³.

Жилас, коммунист парламент нь нийгэмд бодитой, олигтой үүрэг нөлөөгүй байдаг хэрнээ бас хэрэгтэй болдгийг дараах шалтгаануудаар тайлбарлажээ. Бүх зүйлийг хуульчилсан байх ёстой бөгөөд ард түмэн сонгох, сонгогдох эрхээ эдэлж байгаа гэсэн сэтгэгдэлийг тэдэнд төрүүлэх хэрэгтэй болно. Нэр дэвшигчидийг парламентэд сонгохдоо төрд зүтгэсэн байдал, нийгэм дэх статус, ажил мэргэжлийн олон янз байдлыг чухалчлан анхаарна. Коммунист парламент нь чухал шийдвэр гаргадаггүй бөгөөд ерөөс түүнд тийм чадвар ч байхгүй.

⁹² Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 115

⁹³ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 115

Парламент аль хэдийнээ шийдэгдсэн асуудлыг нэгэн дуугаар батлахаас өөр зүйл хийдэггүй. Гишүүд нь парламентаа "бунхантай" зүйрлэдэг ажээ⁹⁴.

Жилас, коммунист төр нь бие хүн, ард түмнийг бүхэлд нь, бүр өөрийг нь хамгаалагч коммунистуудаа ч ямар ч сүр сүлдгүй, өөрөөр хэлбэл өөрөө өөртөө эзэн байх чадваргүй болгож дарладаг гэжээ. Коммунист төр хувь хүнийг хийсвэр санааны нэгж зүйл гэж үздэг байна. Хамгаалалтгүй байдал нь коммунист систем дэх бие хүний амьдралын хэв маяг болдог ажээ. Коммунист нийгэм дэх хүний хамгаалалтгүй байдал гэдэг нь төр иргэнийхээ эсрэг ямар ч үйл ажиллагаа явуулахад бэлэн байдагтай холбоотой юм. Коммунист системд зохион байгуулалттай сөрөг хүчин гарч ирэх бололцоогүй бөгөөд учир нь хүн болгон хяналтанд байдаг.

Жилас, коммунист системд байдал ийм дүр зурагтай байдаг ч гэсэн ард түмэн нөхцөл байдлыг бага багаар ухаарч, алхам тутамдаа жижиг, ялихгүй зүйлс дээр эсэргүүцэл үзүүлж байна, энэхүү эсэргүүцэл нь коммунист дэглэмд тулгараад байгаа хамгийн ноцтой аюул юм гэж үзсэн байна. Коммунист олигархууд ард түмэн нь юу бодож, юу мэдэрч байгааг аль хэдийнээ мэдэхээ больсон, тэд уйтгар гуниг, эгдүүцэлээр дүүрэн далайгаар хүрээлэгдэж өөртөө итгэх итгэл, тайван байдлаа аль эрт алджээ. Коммунист тоталитаризм нь цөхрөл, үзэн ядалтас өөр зүйл үлдээгээгүй бөгөөд бүхнийг хамарсан бухимдалд хөтлөн аваачдаг гэж Жилас бичжээ.

Жилас, коммунист дэглэм дэх эдийн засаг нь дэглэмийнхээ үүсэл төлөвшлийн бүхий л үе шатыг өөртөө тусгаж хамт авч явдаг гэжээ. Төр эхлээд аж үйлдвэржилтийг эрчимжүүлэхийн тулд үйлдвэрлэлийн бүх арга хэрэгсэлийг хяналтандаа авдаг, дараа нь удирдагч анги эдийн засгийг өөрийн ашиг сонирхолын дагуу удирддаг байна. Нийгэмд эд материалын нөөц нэг бүлгийн гарт төвлөрч байгаа нөхцөлд ажиллах хүч хэзээ ч эрх чөлөөтэй байж чадахгүй. Коммунист дэглэмийн нөхцөл дэх эдийн засгийн тухай Жиласын үзэл санаа Ф.Хаекын үзэлтэй тохирч байгааг энд дурдах хэрэгтэй. Тэдний үзэл санааны нийтлэг зүйл бол эдийн засгийн харилцааг бүлэг хүмүүс дангаараа хянаж байгаа нөхцөлд хувь хүмүүс эрх чөлөөтэй байх аргагүй гэсэн үзэл юм. Коммунист эдийн засаг нь үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өсөлтөнд гол анхаарлаа хандуулж, ажиллах хүчийг үр ашигтай хэрэглэх асуудлыг орхигдуулдаг байна. Ийм системд чөлөөт үйлдвэрчний эвлэл, ажил хаялтын тухай ойлголт огт байдаггүй. Ажилчид ажил хаяж болохгүй гэж коммунистууд тайлбарлахдаа: ажилчин анги нь улсын үйлдвэрлэлийн хэрэгсэлийг дам байдлаар өмчлөгч, эзэн нь мөн тул ажил хаяна гэдэг бол тэд өөрсдийгөө хохироож буй утгагүй зүйл гэдэг байна.

Жилас коммунист, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн систем бол хүн төрлөхтөний түүхэн дэх хамгийн үрэлгэн систем юм гэжээ. Коммунист системд улсын өмчийг идэж шамшигдуулах явдал нь жирийн үзэгдэл байдаг ажээ. Югославт зөвхөн 1954 онд нийгмийн өмчийг шамшигдуулсан хорин мянга гаруй тохиолдол илэрсэн байна. Коммунист удирдагчид улсын өмчийг өөрийн мэт

⁹⁴ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 117

эзэмшиж, үрэн таран хийнэ. Жилас үүнийг коммунист системийн өмч, засгийн эрхэд хандах хандлага гэж бичжээ.

Коммунист эдийн засгийн гол шинж нь дэлхийн эдийн засгаас хэтэрхий тусгаарлагдсан байдаг явдал ажээ. Коммунист орнууд коммунист бус орнуудтай эдийн засгийн харилцаанд ордоггүй. Түүхий эд, бараа материалын үнэ дэлхийн зах зээлийн дундаж үнээс зөрүүтэй байдаг бөгөөд эрэлтийг огт тооцолгүй хэнд ч хэрэггүй барааг их хэмжээгээр үйлдвэрлэж тооны хойноос хөөцөлддөг. Энэ бүхэн нь ганцхан олигархуудад хэрэгтэй. Учир нь бие даасан, хараат бус байдал тэдэнд хамгийн чухал зүйл болно. Үүний үндсэн дээр шинэ анги, түүний дээд хэсэг болох олигархууд ноёрхолоо хадгалж чадна. Аливаа дарангуй тоталитар дэглэмүүд гадаад ертөнцөөс хөндий, хаалттай байдаг. Энэ нь тоталитар төр улсын ард иргэд нь өөрийн улс орныг бусад улстай харьцуулан үзэж хандах боломжийг хаах, гаднаас шинэ, чөлөөтэй, олон ургалч үзэл бодол нэвтрэхэд саад болох, эдийн засгийн монополь байдлаа хадгалахад нь тусладаг байна.

Коммунист эдийн засгийн өөр нэг онцлог шинж бол дэлхийн бусад хөгжингүй орнуудтай өрсөлдөж, эдийн засгийн гол салбаруудаар гүйцэж түрүүлэх, техникийн дэвшлийг хэт дөвийлгэхийг оролдох явдал ажээ. Энэ нь эргээд улс орны эдийн засагт хүнд дарамт болдог, ард түмэнд ямар ч ашиг тусгүй хэрнээ коммунист олигархуудад дэглэмээ хадгалж үлдэхэд нь тус болдог байна. Оросын эрдэмтэд номенклатурыг судлаад тэд ард түмнээр өөрсдийгөө хүлээн зөвшөөрүүлж, легитим байдлаа хадгалахын тулд гурван зүйл дээр тулгуурладаг бөгөөд тэдгээр нь үзэл суртал, патернализм, техникийн дэвшил юм гэж үзсэнийг Жилас өөрийн санаа бодолтой холбогдуулж дурджээ.

Жилас бүхэлдээ коммунист системийн эдийн засгийн асуудлыг судлан үзээд дараах дүгнэлтэд хүрчээ. Коммунист эдийн засаг нь нэг дор бүх баялагыг төвлөрүүлсэнээр зарим талаар гайхалтай хурдацтайгаар амжилтанд хүрдэг ч төдийлөн удалгүй эрч хүчээ алддаг. Угаасаа их биш нөөц бололцоо бүхий энэхүү эдийн засаг нь хямралд орно. Түүний ирээдүй тодорхойгүй байна. Ирээдүйд тэсэж, хадгалагдаж үлдэхийн төлөөх дотоод болон гадаад ширүүн тэмцэл өрнөх болно хэмээн бичжээ.

Жилас, коммунистууд засгийн эрхэнд гарсаны дараа хүмүүсийн оюун ухаан, нийгмийн оюун санааны амьдралын бүх хүрээг хянаж, ноёрхолоо тогтоосныг тусгайлан авч үзжээ. Коммунист материализм нь тэвчихийн аргагүй ертөнцийг үзэх үзэл бөгөөд өөртэй нь үл тохирох үзлийн эсрэг хайр найргүй дайрдаг, ерөөс марксизмд универсал арга байдаг гэсэн үзэл нь оюун санааны амьдралын бүх хүрээнд ноёрхолоо тогтооход зайлашгүй хүргэдэг гэж үзсэн байна. Жилас орчин үеийн коммунизмын тэвчишгүй байдал нь дундад зууны үеийн шашны сектүүдийг санагдуулдаг гэжээ⁹⁵. Коммунизм нь яг шашин биш ч гэсэн түүнтэй олон зүйлээрээ төстэй ажээ. Орчин үеийн коммунизм нь Кромвелийн үеийн пуританчуудын үзэл болон яkobинчуудын улс төрийн бодлоготой төстэй, тухайлбал коммунист засаглал яkobинчуудынхтай адилхан

⁹⁵ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 131

юм, харин ялгаатай тал нь гэвэл пуританчууд Библид итгэдэг бол коммунистууд шинжлэх ухааныг тахин шүтэдэг. Гэхдээ хамгийн гол нь ямар ч шашин, эсвэл ямар ч дарангуйлал нь коммунист дэглэм шиг хүний амьдралын бүх талыг хамарсан, хязгааргүй ноёрхолоо тогтоож чадахгүй гэж Жилас бичжээ.

Дундад зуунд хүн сүмд үнэнч гэдгээ дахин дахин гэрчлэх хэрэгтэй болдог байсан бол коммунист дэглэмийн үед иргэн хүн “илүү алхам” хийхээсээ үргэлж айж, социализмын дайсан биш гэдгээ ямагт батлах хэрэгтэй болсон гэдгийг Жилас онцлон тэмдэглэсэн байна⁹⁶.

Коммунист нийгэмд хүнийг төрөхөөс үхэх хүртэл нь нам хүрээлж, оюун санаа, ухамсарт нь нөлөөлдөг ба түүндээ олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийг эрчимтэй ашигладаг байна. Коммунист олигархууд хүмүүсийг эрүүл ухаанаар бодож сэтгэхүй, социализмын эсрэг босож хөдлөхгүй байлгах бүх алхамыг хийдэг ажээ. Коммунист суртал ухуулга нь нь хүмүүст үнэнд хүрэх, шинэ санаа сэдэж тэмүүлэх боломжийг олгохгүй байна. Ийм байдал нь Жиласыг орчин үеийн коммунизмыг шашны сектүүдтэй зүйрлэхэд хүргэжээ.

Коммунист удирдагчид нь эрдэмтэд, ялангуяа техникийн чиглэлийн мэргэжилтэнүүдэд онцгой анхаарал хандуулдаг байна. Учир нь аж үйлдвэржилт, техникийн дэвшил нь сайн эрдэмтэн, мэргэжилтэнгүйгээр хэрэгжих аргагүй. Гэхдээ шинэ бүтээл, шинэ санаа, нээлт нь эргээд ноёрхож буй үзэл сурталд сөрөг нөлөө үзүүлж болно. Эрдэмтэдийн өмнө хоёр зам байдаг. Нэг нь эрсдэл гаргаж өөрийн үзэл бодлоор явах, нөгөө нь албан ёсны үзэл суртлыг дагаж дуулгавартай хөдөлмөрлөх явдал юм. Коммунист систем нь нэг талаар техникийн дэвшилийг хурдасгахыг хичээдэг мөртлөө нөгөөтэйгүүр сэтгэлгээний хаалт хязгаарлалтгүй явагдах ёстой чөлөөт судалгааг хавчин боодог байна.

Коммунист нийгэмд соёл, урлагийн байдал шинжлэх ухаантай яг адилхан байна. Соёл, урлагийн бүтээлүүд өндөр цензур, олон давхар шалгалтаар шүүгдсний дараа л олон түмэнд хүртээлтэй болдог. Жилас Югославын соёл, урлагын толгой дээр хурц илд унжаастай байдаг бол Зөвлөлтийн хувьд шууд зүрхэн дээр нь зүгээстэй байдаг гэж тухайн үеийн нөхцөл байдлыг зүйрлэн илэрхийлжээ. Соёл, урлагийг хянах гол шалтгаан бол тэдгээрээс гарсан шинэ санаа нь урьдчилан тооцох аргагүй үр дүнд хүргэдэг явдал ажээ.

Коммунист дэглэмийн үед хүмүүс хүссэн ч, хүсээгүй ч “өөрийгөө хянахад” хүрдэг байна. Дундад зууны үед зураач зураг зурахынхаа өмнө түүний бүтээл гарсаны дараа сүм хийд хэрхэн хүлээж авах тухай урьдчилж төсөөлөн бодох хэрэгтэй болдог байсан бол коммунист дэглэмийн үед албан ёсоор тогтоосон сэтгэлгээний хэв маяг, бүр нарийн яривал удирдагчын хүсэл сонирхолд тааруулан зурах хэрэгтэй болдог.

Коммунист дэглэмийн үед хахуульдах нь төрийн бодлогын нэг хэсэг болдог, тухайлбал уран бүтээлчид, ер нь бүх хүнийг хахуульдах замаар өөрийн хүсэл зоригын дагуу байлгадаг байна.

⁹⁶ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 133

Жилас, коммунистууд хүмүүсийг үзэл суртлаар ялгаварлан гадуурхдагаараа өөрсдийгөө шашны бүлэглэлээс ялгаагүй болгодог гэжээ. Арьс өнгө, анги, каст, үндэс угсаагаар нь ялгаварлах нь гадна харагдах байдлаараа үзэл суртлаар ялгаварлах явдлаас илүү харгис мэт боловч хэзээ ч бүхнийг хамарч чаддагүй ажээ. Эхэнд дурдсан ялгаварлал нь нийгмийн тодорхой нэг хэсгийг гэмтээдэг бол үзэл сурталын ялгаварлал нь нийгмийг бүхэлд нь, түүний гишүүн бүрийг тус тусад нь хохироодог байна. Жилас оюун санааны хүчирхийлэл бол хамгийн харгис, аюултай нь бөгөөд бусад төрлийн хүчирхийлэл түүгээр эхэлж, түүгээр дуусдаг гэжээ⁹⁷.

Коммунизм нь нийгэм-улс төрийн бусад хөдөлгөөнөөс зорилгодоо хүрэх аргаараа ялгардаг ажээ. Коммунизм төгс зорилгодоо хүрэхийн тулд ямар ч аргыг хэрэглэдэг бөгөөд төгс зорилго нь биелэгдэхгүй, улам бүр бодит бус болох тусам хэрэглэж буй арга нь тэр чинээгээр эрээ цээргүй, ил тод, тэсвэрлэхийн аргагүй болдог ажээ. Коммунизм нь анхнаасаа сайн сайхан ирээдүй, төгс байдлын төлөө гарч ирдэг учир хүмүүсийн хүндэтгэлийг хүлээж, сэтгэлийг нь татдаг байна. Коммунистууд эхэн үедээ өндөр ёс суртахуунтай, нөхдийнхөө төлөө амиа золиослоход ч бэлэн, аливаа зүйлд чин сэтгэлээсээ ханддаг, нэгдмэл санаа зорилготой байдаг. Гэвч энэ бүгд аажмаар багасч, засгийн эрхэнд гарч, эрх мэдэлтэй болох үед нь оргүй алга болно. Зусарч, бялдууч зан, дотуур тамир, хувийн амьдралд оролцох, ичгүүр сонжуургүй карьер хөөх зэрэг сөрөг шинжүүд нь коммунистуудын эхэн үеийн эерэг шинжүүдийг засгийн эрхийн төлөөх тэмцлийн явцад үгүй хийдэг байна. Хувьсгалын өмнөх чин сэтгэл нь хэт улс төржилт, башир залиар солигддог ажээ. Өчигдөрхөн бусдын, бүгдийн төлөө өөрийн амь насаа гаргуунд гаргахад бэлэн байсан баатар эр өнөөдөр хулчгар, амин хувиа хичээгч болж хувирдаг гэж Жилас бичжээ. Жилас үүний учир шалтгаан нь тухайн хувь хүндээ бус, харин коммунист системдээ байна гэж үзжээ. Коммунист удирдагчид нийгэмд ямар нэг зүйл, ажил хэрэг болж бүтэхгүй байгааг мэдэрч, тэр талаар найз нөхдийнхөө хүрээнд олонтоо ярьж хэлэлцдэг боловч ажил хэрэг, зорилгыг гэдрэг татаж буцаахад дэндүү оройтсон байдаг. Коммунист удирдагчид тийнхүү оюун санаа, сэтгэлгээгээрээ коммунизмын олзлогдогч болж хувирна⁹⁸.

Орчин үеийн коммунизм нь хүмүүсийг ноёрхолын үндсэн гурван хэлбэр болох засаглал, өмч, үзэл суртал дээр тулгуурлан дарангуйлж байдаг шинэ хэлбэрийн тоталитаризм мөн бөгөөд ноёрхлын эдгээр хэрэгслийг шинэ ангийн олигархууд хянаж байдаг гэж Жилас үзжээ. Урьд өмнө нь ямар ч дэглэм коммунист тоталитар дэглэм шиг дээрхи гурван хэлбэрээр хүмүүсийг хянаж чадаагүй ажээ. Үзэл суртал ноёрхолд нь гол үүрэг гүйцэтгэдэггүй, харин засгийн эрх, өмч хоёр бол ноёрхолын хамгийн гол хэрэгсэл, коммунизмын дүр төрхийг бүрдүүлэгч болдог байна.

⁹⁷ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992.139

⁹⁸ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992.144

Жилас, коммунизм нь хөгжлийн хувьсгалт, догматик, догматик бус гэсэн үе шатуудыг туулсан гэжээ. Хувьсгалт, догматик үе нь Ленин засгийн эрхийг авсан үе; догматик байдлаас татгалзсан үе нь Сталин социалист системийг байгуулсан үе; догматик бус үе нь “хууль ёсыг” сэргээж, систем тогтворжсон, “хамтын удирдлагын” үе юм. Эдгээр гурван үед хүчтэй засаглал хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Хувьсгалын явцад засгийн эрхийг авах хэрэгтэй байсан, социализмыг байгуулах үед хүчтэй засаглал дээр тулгуурлаж шинэ тогтолцоог байгуулсан бол эцэст нь засгийн эрх нь энэхүү системийн хамгаалагч болж хувирчээ. Эхний үеэс гурав дахь үе хүртлэх коммунизмын мөн чанар нь засгийн эрх нь аливаа зорилгод хүрэх арга хэрэгсэл байснаа өөрөө өөртөө эрхэм зорилго болж хувирсан явдал юм. Нэг, хоёдугаар үед засгийн эрх нь төгс зорилгод хүрэх арга хэрэгсэл байсан бол гуравдугаар үед засгийн эрх нь өөрөө төгс зорилго болж хувирчээ. Жилас засгийн эрхийн төлөөх тэмцэл бол коммунизмын гол мөн чанар нь бөгөөд тэр нь тоталитар, тэвчишгүй, хаалттай байдаг гэж үзсэн байна⁹⁹.

Жилас коммунизм нь орон бүрт янз бүрийн арга зам, онцлогтойгоор илэрэн гарсан бөгөөд одоо байгаа коммунист дэглэмүүд бол нэг үзэгдэлийн олон хэлбэр гэж үзжээ. Зөвлөлт Холбоот Улс, Хятад, Югославт коммунистууд бие дааж, хэний ч тусламж дэмжлэггүйгээр хувьсгалыг эхлүүлж, засгийн эрхийг авчээ. Энэ нь эдгээр гурван улсыг өөр өөрсдийн замаар замнаж, улс орныхоо онцлог байдлыг хадгалсан, бие даасан коммунист дэглэмийг байгуулахад хүргэсэн ажээ. Бусад коммунист улсууд, тухайлбал Зүүн Европын орнуудад коммунист дэглэм Зөвлөлтийн улаан армийн дэмжлэгтэйгээр тогтсон байна. Энэ нь эдгээр улсуудыг ЗХУ-ын дагуул улс болоход хүргэжээ. Зүүн европын орнууд дуртайдаа бус, харин сул дорой байсанаараа хараат байдалд оржээ. Эдгээр оронд нөхцөл байдал тогтворжиж, нийгэм-эдийн засгийн хувьд хөгжих тусам зөвлөлтийн нөлөөнөөс гарах тэмүүлэл нь улам ихсэх болно гэж Джилас тухайн үед бичжээ.

Коммунист хувьсгалыг бие дааж хэрэгжүүлсэн Хятад, Югославын хувьд ЗХУ-тай зайлашгүй зөрчилдөж, өөрийн замаар явахыг эрмэлзнэ гэдгийг Жилас онцлон хэлжээ. Энэ хоёр оронд үндэсний коммунизм буюу өөрийн орны онцлогыг тусгасан зөвлөлтийн бус коммунизм үүссэн ажээ.

ЗХУ ба Югославын хооронд дох зөрчил нь коммунизмын задралын эхийг тавьсан гэж Жилас үзжээ. Энэ зөрчил нь улмаар Зүүн европын орнууд, тухайлбал Польш, Унгарт зөвлөлтийн нөлөөг эсэргүүцсэн, өөрийн замаар замнаж хөгжихийг уриалсан уриа лоозунг, жагсаал цуглаан, хөдөлгөөнүүд гарахад нөлөөлсөн нэг чухал хүчин зүйл болсон байна. Мөн түүнчлэн их гүрний дээрэнгүй үзэл, зөвлөлтийн сургагчид болох цэргийн офицеруудын ёс бус үйлдэл зэрэг олон хүчин зүйлс Зүүн европын орнуудад зөвлөлтийг эсэргүүцэх хөдөлгөөн гарахад нөлөөлжээ. Эдгээр орнууд зөвлөлтийн бус, өөрийн үндэснийхээ шинжийг агуулсан коммунизмыг бүтээхийг зорьсон байна.

⁹⁹ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992. 150

Коммунист орнууд дах дотоод зөрчил нь дан ганц зөвлөлтийн коммунизмаас болоогүй, гол нь зөвлөлтийн империалист бодлоготой холбоотой байсан гэж Жилас үзжээ. Зөвлөлтийн империалист бодлого нь хоёр үе шатыг дамжжээ. Эхний үед бусад орнуудад коммунист хувьсгалыг сурталчилан зохион байгуулж, дэмжлэг үзүүлсэн бол хоёр дах үе шатад аж үйлдвэржилтийг амжилттай дуусгаж, шинэ анги, Сталины ноёрхол тогтсон байна. Энэ үед гадаад явдлын яамыг толгойлж байсан нээлттэй, сэтгэл татам, зарчимч Литвиновыг зарчимгүй, зожиг Молотовоор сольж, империалист бодлого явуулснаар, бусад орнуудад коммунист дэглэмийг хүчээр тулгахад ямар ч асуудалгүй болжээ. Жилас зөвлөлтийн империалист бодлогын гол шалтгаан нь шинэ ангийн дарангуйлагч, мөлжигч уг чанарт оршдог нь ямар ч эргэлзээгүй гэсэн байна. Жилас Югославын үндэсний коммунизм нь зөвлөлтийн империализм, Сталины нөлөөг сулруулахад багагүй нөлөөлсөн бөгөөд коммунизм нь дотоод зөрчилдөө идэгдэж, уналтанд ороод байна гэжээ.

Жилас номынхоо сүүлчийн бүлэгт өөрийн амьдарч байсан үеийн коммунизмын байдал болон дэлхий ертөнцийн дүр төрхийг гаргахыг оролджээ. Дэлхийн нэгдүгээр дайны нөлөөгөөр Хаант Орос, Европын олон оронд нийгэм, эдийн засгийн гүнзгий өөрчлөлт гарчээ. 1929 оны их хямрал нь нийгмийн байгуулал төдийгүй, бүхэл бүтэн үндэстний оршин тогтнолд аюул учруулж болохыг харуулсан байна.

Орчин үеийн дэлхий ертөнцийн дүр төрхийг өөрчилсөн хамгийн гол зүйл бол шинэ үеийн дайн ажээ. Орчин үеийн дайн урьд өмнөх үеийнхтэй харьцуулахад илүү хөнөөлтэй, үр дагавар нь өргөн далайцтай болсон байна. Дайн улс үндэстэн, хүн төрөлхтөнд гүн гүнзгий нөлөө үзүүлж байгаа нь хоёр шалтгаантай гэжээ. Нэгд, орчин үеийн дайн бүхнийг хамарсан шинжтэй болжээ. Хоёрт, дэлхий ертөнц нэгэн нэгдмэл, амьд бүхэл организм болж хувирсан бөгөөд үүний эрхээр биений нь өчүүхэн бага хэсэгт гарсан өөрчлөлт бүх биеийг нь хамарсан том өөрчлөлтөнд хүргэдэг болсон байна. Ирээдүйд дайн тулаан тодорхой улс үндэстэнүүдийн хооронд бус, харин дэлхийг хамарсан, эсвэл иргэний дайны хэлбэртэй байх болно. Дэлхий ертөнцийн ирээдүйг тааварлахын аргагүй, гэхдээ бодит байдал, амьдралын хүч бол ямар ч дарангуйлал, онолоос хүчтэй тул хүн төрөлхтөн эрх чөлөөтэй, хөгжингүй, нэгдмэл байдалд хүрч чадна гэж Жилас үзжээ.

Жилас 1969 онд "Төгс бус нийгэм" гэсэн номоо хэвлүүлж гарсан бөгөөд тэр даруйд нь Югославт худалдаж тараах, уншихыг хоригложээ. Тэрбээр эл номондоо марксизмын үндсэн асуудлуудыг шүүмжилж, ирээдүйн хувь заяаг нь олж харахыг хичээсэн байна. Жилас коммунизм нь орчин үеийн хүний хэрэгцээг хангах чадваргүй бөгөөд дэвшүүлж тавьсан үзэл санаа нь хүмүүсийн сэтгэлийг татахаа больсон гэсэн санааг гаргажээ. Жилас коммунизмын хямрал нь объектив буюу эдийн засгийн шалтгаантай бус, хамгийн гол нь субъектив буюу хүний хүчин зүйлээс үүдэлтэй гэж үзжээ. Хүн ямар ч муу муухайг, ямар ч хүчирхийллийг тэвчдэг ч гэсэн тэрхүү тэвчээр, тэсвэр нь мөнх үргэлжлэхгүй,

хэзээ нэгэн цагт барагдаж эсэргүүцнэ гэсэн байна¹⁰⁰. Коммунист олигархууд, номенклатурчуудтай тэмцэхдээ хувьсгал болон иргэний дайнаас зайлсхийж, жагсаал цуглаан, ажил хаялт, эсэргүүцлийн хөдөлгөөний замыг сонгох нь зүйтэй бөгөөд гэхдээ тэрхүү тэмцэлд хамгийн гол нь ил тод, зоригтой шүүмжлэл, тэвчээр чухал болно. Орчин үеийн коммунист нийгэмд хувьсгал хэрэггүй, харин эдийн засгийн шинэчлэл, ардчилалын үнэт зүйлс хэрэгтэй. ЗХУ дахь аливаа өөрчлөлт нь нийт Европ, бусад коммунист дэглэмд өөрчлөлт авчрах болно гэж Жилас үзэж байжээ.

Жилас, бүтээн байгуулалтанд нь өөрөө гар бие оролцож байгуулсан коммунист нийгэм, өөрөө итгэн үнэмшиж байсан марксист сургаалын алдаа дутагдалыг олж харж чаджээ. Түүний хурц шүүмжлэлт үзэл санаа нь нэгд, хүмүүст бодит байдал, чин үнэнийг харуулахыг хүссэн, хоёрт, нэгэнт хөл дээрээ бат зогссон коммунист дэглэмийг шинэчлэх, алдаа гажуудалыг нь засаж залруулах, сайжруулах зорилготой байв. Жиласын бүтээл туурвил нь нийгэм-улс төрийн судалгаа, тэр дотор тоталитаризм, коммунизм, номенклатур судлалд багагүй хувь нэмрийг оруулж чадсан байна.

Түлхүүр үг: Тоталитаризм, коммунист тоталитар дэглэм, сталинизм, коммунизм, шинэ анги.

Товч хураангуй: Энэхүү өгүүлэл нь Югославын улс төр судлаач, төрийн зүтгэлтэн М.Жиласын "Тоталитаризмын дүр төрх" номонд анализ хийхийг зорьсон болно. Уг бүтээлд Югославын коммунист нам, тоталитар дэглэм дэх социалист төрийн үйл ажиллагааг дэлгэрэнгүй авч үздэг бөгөөд Жиласын Сталинтай уулзаж байсан дурсамжуудыг тодорхой өгүүлсэн байдаг.

ABSTRACT

This article analyzes the ideas and conclusions of the book M. Djilas "Face of totalitarianism." In this book, the Yugoslav political scientist and politician M. Djilas reveals the inner expansion of the Communist Party of Yugoslavia, illustrates the development of socialist state in a totalitarian regime. This book shows the political documentary portrait of Stalin. In this paper, these and other ideas of M. Djilas discussed in aspect of the history of political thought.

НОМ ЗҮЙ

1. Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992.
2. Бутенко А.П. От коммунистического тоталитаризма к формированию открытого общества в России (политические и правовые проблемы). М., 1997. – 48 с.
3. Тоталитаризм. Из истории идеологий, движений, режимов и их преодоления / Руководитель авторского коллектива Я.С. Драбкин, Н.П. Комолова. М., 1996.– 540 с.
4. Торчинов В.А., Леонтьев А.М. Вокруг Сталина. Историко-биографический справочник. Санкт-Петербург, 2000
5. Шляпентох В.Э. Советский союз – нормальное тоталитарное общество. Соц ис. 2000.- 1 2. – с. 115 – 124
6. Milovan Djilas. New Class:Analysis Of Communist System: An Analysis Of The Communist System. Mariner Books. 1982

¹⁰⁰ Милован Джилас. Лицо тоталитаризма. Перевод с сербо-хорватского П. А. Щетинин, Е. А. Полак, О. А. Кириллова. М., 1992.230